

Өвчтөнийг эдгээх нь

Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Даллин Х.Өүкс

Энэ санваарын хүч бидэнд байдаг. Харин бид бүгд үүнийг зохих ёсоор ашиглахад бэлтгэгдсэн байх ёстой.

Дэлхий даяар ороо бусгаа, үймээн самуунтай өнөө үед итгэл бишрэлтэй хүмүүс улам бүр олноороо тайтгарал, эдгэрэлтийн адислалын төлөө Их Эзэн уруу эргэсээр байна. Санваартнууд хуран цугласан энэхүү цугаларалтад хандан би анагаах ухаанаар, итгэлийн залбирлаар, түүнчлэн санваартны адислалаар өвчтөнийг эдгээх талаар үг хэлэхийг хүсч байна

I.

Хожмын Үеийн Гэгээнтнүүд хамгийн сайн анагаах мэдлэг, арга барилыг хэрэглэхэд итгэдэг. Бид эрүүл мэндээ хадгалахын тулд хоол тэжээл, биеийн тамирын дасгал болон өөр аргуудыг хэрэглэдэг. Эрүүл болохын тулд эмч, мэс засалч гэх мэт анагаахын мэргэжилтнүүдийн тусламж авахыг хүсдэг.

Анагаах ухааны аргыг хэрэглэх нь итгэлийн залбирал болон санваарын адислалд итгэж найдахтай зөрчилддөггүй. Хүн санваарын адислал авахаар хүсэх болгонд Бригам Янг “Та нар ямар нэгэн эм хэрэглэж үзсэн үү?” гэж асуудаг байсан. “Үгүй, бид Ахлагч нарын гарыг толгой дээрээ тавиулмаар байна, Тэгвэл эдгэрэх болно гэсэн итгэлтэй байна” гэж хүмүүсийн хариулахыг Ерөнхийлөгч Бригам Янг сонсоод Тэрээр:

“Миний итгэлийн хувьд энэ нь таарахгүй зүйл. Хэрвээ бид өвчтэй байхдаа, мөн Их Эзэнээс биднийг адислахыг, мөн шаардлагатай бүхнийг хийхийг гуйх юм бол, Авралын Сайн мэдээний ойлголтоор, өөрөө газраа борнойдолгүй, үрийг суулгалгүйгээр би Их Эзэнээс тариа буудайгаа ургуулж өгөөч гэж гуйж байгаатай адил болж таарна. Мэдлэгийнхээ хэрээр эдгээж болох бүхнийг хэрэглээд, дараа нь Тэнгэр дэх Эцэгээсээ . . . биеийг минь эдгээх эмийг ариулахыг гуйх нь миний хувьд тохиромжтой юм” гэдэг байжээ<sup>1</sup>

Мэдээжийн хэрэг, бид итгэлээр залбирахаасаа эсвэл эдгээх санваарын адислалыг өгөхөөсөө өмнө анагаах ухааны бусад бүх аргыг хэрэглэсэн байх ёстой биш л дээ. Онцгой тохиолдолд, залбирал, адислалыг эхлээд хэрэглэдэг. Бид бүх талын хүч чармайлтыг нэгэн зэрэг хэрэглэх нь олонтоо байдаг. Энэ бол “үргэлж залбирагтун”

(С ба Г 90:24) хэмээн судруудад заасныг, мөн бүх зүйл мэргэн ухаанд мөн эмх цэгцэнд хийгддэг байх (Мозая 90:24-г үз) зааврыг дагаж мөрдөхтэй холбоотой юм.

## II.

Гэр орондоо, эсвэл шүтэн бишрэх газарт ганцаар хэлсэн итгэлийн залбирал өвчтөнийг эдгээх үр нөлөөтэй гэдгийг бид мэднэ. Олон сударт, хувь хүнийг эдгээхэд итгэлийн хүч нөлөөлдөг тухай өгүүлсэн байдаг. Төлөөлөгч Иаков бидэнд “Бие биеийнхээ төлөө залбир. Ингэснээр та нар эдгээгдэх болой” мөн “Зөвт хүний залбирал үр нөлөөтэй” (Иаков 5:16) хэмээн заасан юм. Есүст гар хүрсэн эмэгтэй эдгэрэхэд, Тэрээр уг эмэгтэйд, “Итгэл чинь чамайг эдгээлээ” гэж хэлсэн байдаг (Матай 9:22)<sup>3</sup>. Үүний адилаар, Мормоны Номонд, Их Эзэн “хүмүүний үрсийн итгэлийн дагуу хүчээр үйлддэг . . .” болохыг заасан юм (Моронай 10:7).

Улс даяар саяхан явуулсан нэгэн судалгаагаар, 10 америк хүний 8 нь “гайхамшгууд, эрт дээр үед тохиодог байсны адил одоо ч тохиодог гэдэгт итгэдгийг” харуулжээ. Судалгаанд оролцсон хүмүүсийн гуравны нэг нь “тэнгэрлэг эдгэрэлтийг биеэр үзсэн эсвэл харсан” гэж хариулжээ<sup>2</sup>. Хожмын Үеийн олон Гэгээнтэн өвчтөнийг эдгээх итгэлийн хүчийг биеэр үзсэн байдаг. Мөн бусад сүмийн итгэл бишрэлтнүүдийн дунд иймэрхүү зүйл тохиодог талаар бид олонтоо сонсдог. Техас муж улсын сонины нэг ажилтан дараах гайхамшгийг дүрслэн бичжээ. 5 настай нэг охин гэнэт амьсгаа нь бачимдан, халуурч эхэлсэн гэнэ. Эцэг эх нь түүнийг тэр дор нь эмнэлэгт аваачжээ. Эмнэлэгт очих үед бөөр, элэг нь ажиллахаа больчихсон, халуун нь 41.7 градус хүрсэн байж. Бие нь бүхэлдээ улайж, ягаан өнгийн гүвдрүү туурсан байжээ. Эмч нар түүнийг үл мэдэгдэх хорт бодисноос хордож, өвчин нь үгдэрсэн байна гэж оношилсон гэнэ. Гэр бүл, найз нөхөд энэ мэдээг сонсоод, Бурханаас эмээгч тэд охины төлөө залбирч, дээр нь мөн Техас муж улсын Вакод, протестант шашинтууд онцгой залбирлын цуглаан хийжээ. Нөгөөх охин гайхамшигтайгаар үхлийн ирмэг дээрээс буцан ирж, эмнэлгээс долоо хоногийн дараа гарчээ. Өвөө нь “Ач охин маань, Бурхан залбиралд хариулж, гайхамшгийг үйлддэгийн амьд жишээ боллоо” гэж бичжээ.<sup>5</sup>

Үнэхээр, Мормоны Номонд заадгаар, Бурхан “Ариун Сүнсний хүчээр тэрээр өөрийгөө түүнд итгэх тэд бүгдэд үзүүлнэ гэдэгт; тийм ээ, үндэстэн, ястан, хэлтэн, мөн хүмүүс болгонд, хүчит гайхамшгууд . . . -ыг хүмүүний үрсийн дунд тэдний итгэлийн дагуу үйлдэнэ” (2 Нифай 26:13).

## III.

Энэ хуралдаанд оролцогчдод – Мелкизедек санваартан эрэгтэйчүүд болон энэхүү хүчийг удахгүй хүлээн авах залуу эрэгтэйчүүдэд – би санваарын хүчийг ашиглан эдгээх адислалын талаар голчлон ярих болно. Бидэнд энэ хүч байдаг. Бид бүгд үүнийг зөв ашиглахад бэлтгэгдсэн байх ёстой. Сүүлийн үед байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал газар авсаар байгаа нь бидэнд энэхүү хүч ирээдүйд өнгөрсөн үеэс илүү хэрэгтэй болно гэдгийг харуулж байна.

Их Эзэний зарц нар “өвчтэй хүн дээр тэд гараа тавибал эдгэнэ” гэж олон сударт өгүүлдэг (Марк 16:18)<sup>6</sup>. Санваарын эрх мэдлийг өвчтөнийг эдгээхийн тулд ашигласан үед гайхамшгууд тохиодог. Би ийм гайхамшигтай учирч байсан хүн. Би бага насны хөвгүүн байхдаа ч насанд хүрсэн үедээ ч, та нарын олонхийн адил, судруудад тэмдэглэгдсэн гайхамшигт эдгэрлийг харж байлаа.

Өвчтөнийг адислахын тулд санваарын эрх мэдлийг ашиглах нь: (1) тослох, (2) тос түрхэлтийг лацдах, (3) итгэл, (4) адислалын үгс болон (5) Их Эзэний хүсэл гэсэн 5 хэсгээс бүрддэг.

### **Тос түрхэх**

Хуучин Гэрээнд, санваарын эрх мэдлийг ашиглан адислал өгөхөд тос түрхэх нь адислалын нэг хэсэг болох тухай үе үе дурдагддаг.<sup>7</sup> Энэхүү хатуу тогтсон ёслол нь ариусгалд<sup>8</sup> зориулагдсан байлаа. Энэхүү ариун ёслолын ачаар Тэнгэрээс олон адислал ирэхийн бэлгэдэл гэж үзэж байсан байж магадгүй юм.

Шинэ Гэрээнд, Есүсийн Төлөөлөгчид “өвчтэй олон хүнд тос түрхэн эдгээсэн байдаг” (Марк 6:13). Иаковын номонд, санваарын эрх мэдлийг ашиглан эдгээх адислал өгөхөд тос түрхэхийн чухлыг бусад хэсгүүдтэй холбон заадаг:

“Та нарын дунд хэн нэгэн нь өвчтэй байна уу? Тэр нь чуулганы ахлагчдыг дуудаг.

Тэд Эзэний нэрээр түүнийг тосоор тосолж, түүний төлөө залбираг:

“Итгэлийн залбирал нь өвчтэй нэгнийг эдгээж, Их Эзэн тэр хүнийг босгоно” (Иаков 5:14 -15).

### **Тос түрхэлтийг лацдах**

Мелкизедек санваарын эрх мэдлээр тос түрхүүлсэн үед тос түрхэлтийг адил эрх мэдлээр лацаддаг. Ямар нэг юмыг лацдах гэдэг нь батламжлах, зорилгынх нь тул холбох гэсэн утгатай. Өвчтэй хүнд тос түрхэж, тос түрхэлтийг лацаддаг ахлагч нар , Их Эзэн тухайн хүний төлөө хүссэн адислалаа юүлэхэд зориулан тэнгэрийн цонхыг нээж өгдөг.

Ерөнхийлөгч Бригам Янг: “Би өвчтөний толгой дээр гараа тавихдаа, Бурханы эдгээх хүч, нөлөө надаар дамжин өвчтөнд хүрч, өвчин нь илааршина гэж боддог . . . “Бид бэлтгэлтэй байгаа үед, Их Эзэний ариун сав байгаа үед, Бүхнийг Чадагчаас хүч урсан ирж, гүйцэтгэгчийн биеэр дамжин өвчтөний биед хүрдэг, тэгээд өвчтөн эдгэрдэг. . . .” гэж заажээ.<sup>4</sup>

Ийм эдгэрэлт олон удаа тохиодгийг бид мэднэ. Гэвч орчин үеийн илчлэлтэд “эдгээр зүйлүүдээр тэд өөрсдөө сагсуурах ч, мөн дэлхийн өмнө тэдгээрийг ярих ч ёсгүй. . . ; учир нь эдгээр зүйлүүд та нарын ашиг тус хийгээд авралын төлөө та нарт өгөгдсөн бөлгөө” (С ба Г 84:73) хэмээн сэрэмжлүүлдэг учраас бид нийтийн цуглаан дээр тэдгээр зүйлсийн талаар бараг дурддаггүй.

### **Итгэл**

Тэнгэрийн хүчээр эдгэхэд итгэл зайлшгүй шаардлагатай. Мормоны Номонд, “хэрэв хүмүүний үрсийн дунд итгэл үгүй бол Бурхан тэдний дунд ямар ч гайхамшигийг үйлдэж эс чадах буюу” хэмээн заадаг (Ифер 12:12). Өвчтөнийг адислах тухай Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл онцгойлон өгүүлсэн нь:

“Итгэл хэр зэрэг шаардлагатай болохыг заримдаа чухалчлан үздэггүй. Өвчтэй хүн болон гэрийнхэн нь заримдаа ёслол гүйцэтгэж байгаа ах нарт байдаг санваарын хүч, эдгээх бэлэгт бүрэн итгэж найддаг. Гэвч адислал авч байгаа хүн бүр илүү хариуцлагатай байх ёстой. Өвчтөн ухамсартай, хариуцлагатай байгаа үед түүний итгэл хамгийн чухал юм. “Итгэл чинь чамайг эдгээлээ” (Матай 9:22) гэсэн үгсийг Эзэн олон удаа давтан хэлсэн байдаг нь чухамдаа дууны дахилтын үгс шиг болжээ” гэсэн байдаг.<sup>11</sup>

Ерөнхийлөгч Кимбалл, “Байн байн адислал гүйцэтгүүлэх нь итгэл дутмагийг эсвэл итгэлтэй байх хариуцлагыг өвчтөн өөр дээрээ биш ахлагч нарт үүрүүлэхийг хичээдгийг харуулж байгаа хэрэг гэж хэлж болно” гэжээ. Тэрээр санваарын адислал авсан нэг эгчийн тухай ийн өгүүлжээ. Дараагийн өдөр нь дахин ёслол гүйцэтгүүлмээр байна уу гэж асуухад, тэр эмэгтэй: “Үгүй ээ, надад тос түрхэж, ёслолыг гүйцэтгэсэн. Одоо итгэлээрээ дамжуулан хүлээн авсан адислалаа бодитой болгох нь миний үүрэг” гэж хариулжээ.<sup>12</sup>

### **Адислалын үгс**

Санваарын адислалын өөр нэг хэсэг нь, санваартан тос түрхэлтийг лацадсаны дараа хэлдэг адислалын үгс юм. Эдгээр үгс туйлын чухал ч, утга агуулга нь тухайн үедээ л хэрэгтэй бөгөөд Сүмийн баримт бичигт хадгалагддаггүй. Патриархын адислал гэх

зэрэг санваарын зарим адислалд, хэлсэн үгс нь адислалын гол цөм нь болдог. Харин эдгээх адислалд бол адислалын бусад ёслол – тос түрхэх, лацдах, итгэл болон Их Эзэний хүсэл нь – зайлшгүй шаардлагатай хэсэг байдаг. Ёслолыг гүйцэтгэж буй ахлагч Их Эзэний Сүнстэй холбоотой байж, адислал өгөхдөө Их Эзэний хүслийг мэдэж, мөн үүнийг илэрхийлснээр хамгийн сайн адислал болно. Бригам Янг: “Их Эзэний үгс та нарт хэлэгдэх үед, Их Эзэний оюун ухаан та нарт илчлэгдэхэд, түүнийг нь мэдэж, тэр дагуу амьдрах нь та нарын онцгой боломж, үүрэг мөн”<sup>13</sup> гэж санваартнуудад заасан юм. Энэ тохиолдолд, өгсөн адислал ширхэгчлэн, гайхамшигтайгаар биелэгддэг. Зарим онцгой тохиолдолд, би эдгээх адислал өгөхдөө ийм удирдамжийг баттай мэдэрсэн бөгөөд Их Эзэний хүсэл болон үгс миний амаар дамжин гарч байгааг мэдэж байлаа. Гэвч, эдгээх адислал өгдөг ихэнх хүмүүсийн адил, юу хэлэх ёстой талаараа эргэлзсэн удаа надад олон байсан. Бид сүнслэг байдлын хувьд өөр өөр төвшинд байдаг, сүнслийн өдөөлтийг өөр өөр хэмжээгээр мэдэрдэг. Тухайн өвчтөний төлөөх бидний хүсэл бидэнд өөрсдөд маань нөлөөлж болдог. Энэ бас бидний хэлэх үгсэд нөлөөлж болно.

Эдгээх адислалд хэлэх үгс эдгээх нөлөөний чухал хэсэг биш. Хэрвээ өвчтөн хангалттай итгэлтэй бол, хэрвээ Их Эзэн хүсэх юм бол, гүйцэтгэгч үгсийг хэлсэн ч, хэлээгүй ч, өвчтөн нь эдгэрч эсвэл адислагдах болно. Нөгөө талаас, хэрвээ ёслол гүйцэтгэгч нь хувийн хүсэл, туршлагагүйгээс болж, өвчтөний итгэлийнх нь дагуу Их Эзэний өгөхөөр шийдсэнээс илүүг адислал өгөхдөө хэлэх буюу тушаал өгвөл, үгс биелэгдэхгүй байж болно. Үүний улмаас, ахлагч хэлэх үгээ мэдэхгүй байх гэж эмээн, эдгээх адислалыг өгөхөөс зайлсхийх ёсгүй. Эдгээх адислалд хэлэх үгс нь сонсох хүмүүсийн итгэлийг бэхжүүлж, гэгээрүүлж чадна. Гэвч адислалын нөлөө нь ёслолыг гүйцэтгэсэн ахлагчийн хэлсэн үгсээс биш, харин түүний итгэл болон Их Эзэний хүслээс шалтгаална.

### **Их Эзэний хүсэл**

Залуу болоод настай эрчүүд ээ, одоо миний одоо хэлэх зүйлийг онцгой анхаараарай. Бид Бурханы санваарын эргэлзээгүй хүчийг ашиглах үедээ, Тэрээр итгэлийн залбирлыг сонсож, хариулдаг гэсэн Түүний амлалтыг санан, санваартны итгэл, эдгээх хүчийг Түүний хүслийн эсрэг хэрэглэж болохгүй гэдгийг бид үргэлж санах ёстой. Санваар бол Түүнийх юм. Сүмийн ахлагч нар өвчтөний толгой дээр гараа тавих тухай илчлэлтэд энэ зарчмыг заасан байдаг. “Надад эдгэрэх итгэлтэй,

мөн үхэлд оноогдоогүй тэр нь эдгэрэх болно” (С ба Г 42:48) гэж Их Эзэн амласан билээ. Үүн лүгээ адил, орчин үеийн өөр нэгний илчлэлтэд Их Эзэн, хэн нэгэн нь “Бурханы тааллын дагуу асуувал . . . энэ нь бүр түүний асуусанчлан үйлдэгддэг болой” хэмээн тунхаглажээ (С ба Г 46:30).<sup>14</sup>

Их Эзэний үйлчлэгчид, Түүний тэнгэрлэг хүчийг ашиглан эдгэрэх хангалттай итгэлтэй хүнд ч гэсэн, хэрвээ Их Эзэний хүсэлд нийцэхгүй байгаа бол түүнийг эдгээх санваарын адислал өгч чадахгүй гэдгийг бид энэ бүхнээс сурч мэднэ. Бидний үүрд мөнхийн сайн сайхан байдалд юу хамгийн сайн болохыг Тэр мэддэг гэдгийг мөн Түүний агуу хайрыг мэддэг Бурханы хүүхдүүд бид Түүнд итгэдэг. Сайн мэдээний анхдагч зарчим нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл юм. Итгэл гэдэг нь найдвар гэсэн үг. Хүнд өвчнөөс болж хорвоог орхисон арван хэдтэй охины оршуулгын ёслол дээр манай нэг хамаатан үг хэлэхэд би тэр найдлагыг мэдэрч байлаа. Эхлээд намайг гайхашруулж, улмаар гэгээрүүлсэн дараах үгсийг тэр хэлж билээ: “Тэр охин хорвоог орхисон нь Их Эзэний хүсэл байсныг би мэднэ. Түүнд сайн эмчилгээ хийсэн, санваарын адислал өгөгдсөн. Түүний нэр ариун сүмийн залбирлын нэрсийн жагсаалтанд байсан. Охиныг эдгэрч, эрүүл болохын төлөө зуу зуун залбирал хэлэгдсэн. Түүнийг энэ үед гэртээ аваачих нь Их Эзэний хүсэл биш байсан бол тэр эдгэрэх байсан гэж гэрийнхэн нь баттай итгэж байсныг би мэднэ” гэж тэр хэлсэн юм. Мөн арван хэдэн настайдаа нас барсан өөр нэг сор болсон охины эцгийн хэлсэн үгэнд би тийм найдварыг мэдэрсэн юм. Тэрээр: “Манай гэр бүлийн итгэл Есүс Христэд төвлөрдөг бөгөөд энэ нь бидний итгэлийн үр дүнгээс хамааралгүй юм” гэж хэлж билээ. Түүний энэ үг миний хувьд үнэн юм. Бид хайрт нэгнийгээ эдгэрэхийн төлөө чадах бүхнээ хийдэг, Харин үр дүн нь ямар байхыг бид Их Эзэнд даатгадаг.

Бурханы санваарын хүчийг, итгэлийн залбирлын хүчийг, эдгээр зарчмууд үнэнийг би гэрчилж байна. Бүхнээс түрүүнд Их Эзэн Есүс Христийн тухай, бид түүний үйлчлэгчид гэдгийг, Түүний Амилалт үхэшгүй байдлын баталгааг, Түүний Цагаатгал Бурханы бэлгүүдээс хамгийн агуу нь болох мөнх амьдралын боломжийг бидэнд олгодгийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен.

## ЭШЛЭЛ

1. *Discourses of Brigham Young* (1954), 163.

2. Мозая 4:27-г үз.

3. Марк 10:46-52; Лук 18:35-43-ыг үз. .

4. *U.S. Religious Landscape Survey: Religious Beliefs and Practices: Diverse and Politically Relevant* (The Pew Forum on Religion and Public Life, June 2008), 34, 54, <http://religions.pewforum.org/reports#..>

5. Steve Blow, “Sometimes, ‘Miracles’ Are Just That,” *Dallas Morning News*, Jan. 30, 2000, 31A-г үз.

6. Матай 9:18; Марк 5:23; 6:5; 7:32-35; 16:18; Лук 4:40; Үйлс 9:12, 17; 28:8; Сургаал ба Гэрээ 42:44, 48; 66:9-ийг үз. .

7. Жишээ нь, , Египетээс Гарсан нь 28:41; 1 Самуел 10:1; 16:13; 2 Самуел 5:3-ыг үз..

8. Левит 8:10-12-ыг үз.

9. *Teachings of Presidents of the Church: Brigham Young* (1997), 252; мөн Рассел М.Нелсон, “Neither Trust in the Arm of Flesh,” *Луахона*, Мар. 2010 оны 3-р сар, 40; *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 474-ийг үз.

10. 1 Нифай 7:12; Сургаал ба Гэрээ 35:9-ийг үз.

11. “President Kimball Speaks Out on Administration to the Sick,” *Tambuli*, 1982 оны 8-р сар, 36-37.

12. *Tambuli*, 1982 оны 8-р сар, 36

13. *Teachings: Brigham Young*, 68.

14. Мөн 1 Иохан 5:14; Хиламан 10:5-ыг үз.